



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/197

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны XII хуралдааны 14, 2022 оны ээлжит XVI хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллгааны хөтөлбөрт туссан Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд 2023 оныг Хөвсгөлд зочлох жил болгон зарласантай холбогдуулан “Аялал жуулчлалын менежментийг сайжруулах, нэрлэсэн жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох” зөвлөх үйлчилгээний зардалд 20.000.000 (Хорин сая) төгрөгийг зарцуулсугай.

2. “Аялал жуулчлалын менежментийг сайжруулах, нэрлэсэн жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох” зөвлөх үйлчилгээний зардлын 20.000.000 (Хорин сая) төгрөгийг Засаг дарга дансны “Хөвсгөлд зочлох жил” нэрлэсэн жилийн арга хэмжээний зардал”-аас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх ажлыг Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН